



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 8/118

Дэлгэрхаан сум

Шинжлэх ухааны бүтээлийн наадамд оролцох  
сурагчдын баг бүрэлдэхүүнд дэмжлэг  
үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сумын Засаг даргын үйл ажиллгааны мөрийн хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 2.1.1.1 дэх заалт болох гэр бүл болон нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулж, өсвөр үе, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд Сатоши Омурагийн нэрэмжит шинжлэх ухааны бүтээлийн наадамд оролцох сурагчдын баг бүрэлдэхүүнд дэмжлэг үзүүлэх зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Тэмцээнд оролцсон үйл ажиллагааны явцыг зургаар баталгаажуулж, тайлагнахыг Ерөнхий боловсролын сургуулийн хими биологийн багш (Б.Амарбаясгалан)-д даалгасугай.

3.Үйл ажиллагаанд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



2325010764

